



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2023 оны А/02 дугаар тушаалаар баталсан, А/67 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн нэгдсэн удирдамжаар гүйцэтгэв.

**ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН КОМИСС ХУВЬЧЛАЛЫГ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:



ДАРХАН-УУЛ АЙМАГ

2023 оны 10 дугаар сар

Аудитын зорилго, зорилтууд:

Хүүхдийн зуслангийн хувьчлал хууль тогтоомжид нийцсэн эсэхэд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх;
- Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх;
- Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүнг нь тооцсон эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Аймгийн ИТХ, ЗДТГ, Архивын газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газрын 1991-2003 оны үйл ажиллагааг хамруулсан

БҮЛЭГ А. ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН КОМИССЫН ШИЙДВЭР ХУУЛЬД НИЙЦСЭН БАЙНА.

Хүүхдийн зуслангийн хөрөнгийг хуульд заасны дагуу Өмч хувьчлалын комиссын шийдвэрээр хувьчилсан байна.

Дархан хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны Өмч хувьчлалын комиссын 1992 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Зулзагын голд байрлах Монгол хүүхдийн хуучин пионерын зуслангийн 28 байшинг 21 иргэнд 992 ширхэг тасалбараар хувьчилжээ. Энэ нь Өмч хувьчлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹ дэх хэсэгт заасантай нийцэж байна.

Энэ нь хүүхдийн зусланд ажиллаж байсан ахмадуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр 71.2 хувийг, Зулзагын голд амьдардаг мал бүхий иргэдийн хүсэлтээр 28.8 хувийг тус тус хувьчилсан байна. Хувьчлалд хамрагдсан иргэдийн 70 хувь нь тэтгэврийн насны иргэд байжээ.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ирүүлсэн лавлагаанаас үзэхэд дээрх иргэдийн 47.6 хувь нь буюу 10 иргэн нас барсан, 9 хүний хаяг, байршил нь тодорхойгүй байна.

БҮЛЭГ Б. ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ХУВЬЧЛАХДАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Эд хөрөнгийг хувьчлахдаа дуудлага худалдаа зохион байгуулаагүй, шинэ өмчлөгчийн эрхийг нотолсон гэрчилгээ олгоогүй байна.

Дархан-Уул аймагт амьдарч байгаа 70-83 насны 2 иргэнтэй утсаар холбогдож, ярилцахад өргөдөл хүсэлт гаргаад тасалбараар худалдан авсан, харин тухайн байшинг хувьчлан авсан гэх баримт өгөөгүй гэсэн тайлбар өгсөн.

¹ Өмч хувьчлах ажлыг улсын хэмжээнд БНМАУ-ын Засгийн газар, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжид тухайн Ардын Хурал, түүний гүйцэтгэх захиргаа нэгдсэн удирдлагаар хангаж, улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ

Үүнээс үзэхэд дуудлага худалдаа зохион байгуулаагүй, өмч эзэмших гэрчилгээ өгөөгүй нь Өмч хувьчлах тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Бага хувьчлалд хамаарах эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах замаар хувьчилна”, 9 дүгээр зүйлд “Хөрөнгийг хувьчлах шийдвэр гаргасан байгууллага нь хувьчилсан эд хөрөнгийн шинэ өмчлөгчийн эрхийг нотолсон гэрчилгээ олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

БҮЛЭГ В. АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГТ ХУВЬЧЛАЛТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ МАТЕРИАЛ БАЙХГҮЙ БАЙНА.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл, холбогдох нотлох баримтыг цуглуулахад хүндрэлтэй байлаа.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ирүүлсэн лавлагаанаас үзэхэд дээрх иргэдийн 47.6 хувь нь буюу 10 иргэн нас барсан, 9 хүний хаяг, байршил нь тодорхойгүй байна.

Аудитаар аймгийн архиваас 30 гаруй жилийн өмнөх хүүхдийн зуслангийн хувьчлалтай холбоотой аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн тогтоол, хурлын тэмдэглэл, өмч хувьчлалын комиссын хурлын тэмдэглэл, санхүүгийн тайлан зэрэг баримт материал байгаагүй бөгөөд зөвхөн тасалбараар байр авсан 21 хүний өргөдөл, хүсэлт байгаа нь шаардлагатай мэдээлэл, холбогдох нотлох баримтыг цуглуулахад хүндрэлтэй байлаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Өмч хувьчлах тухай хуульд заасны дагуу Өмч хувьчлалын комиссын 1992 оны 58 дугаар тогтоолоор хүүхдийн зуслангийн 28 байшинг 21 иргэнд 992 ширхэг тасалбараар хувьчилжээ.
- Эд хөрөнгийг хувьчлахдаа дуудлага худалдаа зохион байгуулаагүй байна.
- Хувьчлалд оролцсон иргэдэд эд хөрөнгийн шинэ өмчлөгчийн эрхийг нотолсон гэрчилгээ олгоогүй байна.